

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)

Мэдээллийн эмхэтгэл № 11 (2018 он 4-р сар)

НҮБ дэх дадлага: Ирээдүйн зам

НҮБ-д ажиллах сонирхолтой Япон хүмүүст JPO (Junior Professional Officer) гэх тогтолцоо байдаг. Энэ нь Япон улсын засгийн газраас цалин, урамшууллыг нь олгон НҮБ-д 2 жил ажиллах тогтолцоо юм. Би ч гэсэн нэг удаа шалгалтыг нь өгч байсан хэдий ч харамсалтай нь тэнцээгүй юм. Түүний өмнө өөрийн ур чадвар, туршлага хангалтгүй байгааг дадлагын үеэр сайтар ойлгосон. НҮБ-д ажиллахын тулд англи хэлний өндөр чадвараас гадна тус салбартаа 3-с доошгүй жил ажилласан туршлагатай байх ёстой ба нарийн мэргэжлийн ур чадвар бас шаардлагатай байлаа. Миний олон улсын байгууллага дахь туршлага ердөө л энэ дадлага буюу нийт 6 сар л юм. Дээрээс нь ажил дээр гараад нөхцөл байдлыг ч сайн мэдэхгүй, мэдлэг ч дутмаг байсан. Тийм болохоор надад хэрэгтэй зүйл нь эхний ээлжид хөгжиж буй оронд ажиллан туршлага хуримтлуулах явдал гэж ойлгосон юм. Тэгээд интернетээр хөгжиж буй оронд ажиллах боломжийг судалж эхэлсэн. Тэгэх явцад Японы төрийн бус байгууллагаас Камбожид ажиллах хүн хайж байсан тэгэхэд л надад энэ миний боломж гэж бодогдсон!!



DPUB Ахлах зөвлөх Чича Хисао

Тэгж санагдсан боловч, сэдэв нь “Далан байгуулалт хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөний судалгаа ба зөвлөмж” байв. Энэ ч гэсэн миний туршлагатай огт холбогдолгүй байлаа. Гэхдээ хөдлөхгүй л бол юу ч эхлэхгүй гэж бодоод тэнцэх болтугай гээд материалаа өгсөн дөө...(Үргэлжлэл бий)

DET сургагч багш бэлтгэх сургалт амжилттай үргэлжилж байна. (2018.4.12)



JICA-н Күно мэргэжилтэн

4-р сарын 10-ны өдөр эхэлсэн Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын сургагч багш бэлтгэх сургалт 3 дахь өдрөө амжилттай үргэлжлэн явагдаж байна. Сургалтанд нийт 18 хүн хамрагдаж байгаа бөгөөд бүгд хичээлээс хоцрохгүй, таслахгүй идэвхтэй суралцаж байна. Мөн эхний төгсөгчдөөс (2016) шалгарсан 6 сургагч багш ахлах сургагч болохоор суралцаж байгаа юм. Тэд Япон улсаас ирсэн ЖАЙКА-ийн мэргэжилтэн Күногоос зааварчилгаа авч, сургалтанд оролцогчдыг дэмжин ажиллаж байна. Ахлах сургагч багш нар “Өглөө эрт ирж сургалтын бэлтгэл хангах, сургалт дууссаны дараа тухайн өдрийнхөө хичээлийг дүгнэх... гэх мэтээр өдөр бүр завгүй байгаа хэдий ч бидний хувьд түвшин ахиж боломж болж байна.” хэмээн сэтгэгдлээ илэрхийлж байлаа. Өнөөдөр тус сургалтын хамгийн чухал сэдэв болох “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын талаар хичээл орж байна. Оролцогчдод бүрэн дүүрэн ойлголт өгөхийн тулд ахлах сургагч багш нар, төслийн ажилчид өнөөдөр ч гэсэн хичээн ажиллах болно!



Багануур дүүрэгт сургалт зохион байгууллаа. (2018.03.29)

3-р сарын 29-ний өдөр Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын 4 сургагч багш туслах ажилчдын хамт Багануур дүүрэгт сургалт хийлээ. Багануур дүүрэг нь Улаанбаатар хотын төвөөс машинаар 2 цаг хагас яваад очих газарт байдаг. Энэ удаагийн сургалтын үндсэн сургагч багшаар Гэрэлцэцэг (хөдөлгөөний бэрхшээлтэй), Болороо (тархины саажилттай) нар ажилласан бөгөөд дүүргийн албан хаагчдад зориулж “Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?”, “Миний үйл ажиллагаа” гэсэн сэдвүүдээр оролцоонд тулгуурласан сургалт явууллаа.

Сургалтанд хорооны албан хаагчид, харуул, цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан ажилчид гээд олон хүмүүс хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт нь ч гэсэн өөр өөр байсан тул хариуцсан сургагч багш нар “сургалтаа явал амжилттай явуулах вэ...” гэдэг талаар нэлээн бодолцлоо. Сургалт эхлэх үед “3 цагийн сургалт юм уу, ямар урт юм бэ” гэх хүмүүс байсан ч гэсэн зураг, видео бичлэг ашиглан багаараа дасгал ажиллах явцад “Хороондоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан автомашины зогсоол гаргах хэрэгтэй”, “Дохионы хэл мэдэхгүй боловч угтан авах хэсэгт цаас, бал бэлтгэж тавин, сонсголын бэрхшээлтэй иргэдтэй бичгээр харилцацгаая” гэх мэтээр идэвхтэй оролцож байлаа. Оролцогчдын хандлага ойлголт өөрчлөгдснийг хараад сургагч багш нар урам зориг авсан гэдэгт итгэлтэй байна.



“Бэрхшээл гэж юу вэ?” бусаддаа танилцуулж байн

JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!



Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **1922** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Төслийн талаар “Цагийн хурд” нэвтрүүлгээр цацагдлаа (2018.04.12)



DET Сургагч багш бэлтгэх сургалтын явц болон алхлах зөвлөх Чича Хисаогийн ярилцлага мэдээгээр цацагдлаа.

Мэдээг доорх линкээс хүлээн авч үзэх боломжтой:
(35 дахь минутаас нь үзнэ үү)

<http://www.mnb.mn/i/139302>

Мэдээний агуулга:

“Монгол ХБИ-дэд тусалж байна гээд тусгаарлах нь их байдаг байна.

ЛСА-н DRUV төслийн зүгээс Япон улсын туршлагыг Монголд нутагшуулахыг хүссэн ХБИ-ийн хүсэлтийн дагуу бид олон төрлийн сургалтуудыг зохион байгуулж байгаа.

Монгол улсад ХБИ-г тусгаарласан тусгай сургууль, эмнэлэг бүр тусгай орон сууц хүртэл байдаг. Энэ нь сайн хэрэг хэдий ч ХБИ-д нийгмээс тусгаарласан орчин бий болгох нь алдаа хэмээн олон улст үзэж байна. Төр нийгмийн дэд бүтэц, олон нийтийн хандлагыг ХБИ-д ээлтэй болгохоос илүү тусгаарлах хандлага байна.

Харин Япон улст 1990 оноос хойш ХБИ-г нийгмээс тусгаарлах эсрэг бодлого хэрэгжүүлж байгаа ба Японд оршин буй ХБИ-д бараг бэрхшээл мэдрэлгүйгээр нийгэмд оролцох боломжтой болоод байгаа. ХБИ-д нь нийгэмд оролцоход нийгэм нь өөрөө бэрхшээлээ багасгах шаардлагатай тиймээс нийгмийн орчин, мэдээллийн хүртээмж, дэд бүтцээ сайжруулах шаардлагатай юм.

Манай орон ХБИ-г дэмжсэн хуультай боловч хэрэгжилт дээр олон асуудлууд байгааг ХБИ-д хэлж байна. Халамж тэтгэлгээс илүүтэйгээр нийгмийн харилцаанд ямар нэгэн саадгүй, ялгамжгүй оролцох нь чухал байгааг онцоллоо.”



Нэвтрүүлгийн хэсгээс

Төслийн шинэ ажилтанг танилцуулж байна

Манай төсөлд шинээр орсон ажилтан болох Батбаярыг танилцуулж байна.

Энэ төсөлд орсноор анх ХБИргэдийн талаар анх удаа нухацтай бодож үзлээ. Өмнө би өөрөө ч гэсэн өөрийн мэдэлгүй ХБИ-г нийгмээс тусгаарлах хандлагатай байсныг мэдэрсэн юм. Тиймээс илүү нийгмийн хандлага, хотын дэд бүтэц, улсын бодлогыг бага багаар ч болсон сайжруулан ХБИ-д илүү таатай орчин нөхцөл бүрдүүлэхэд тус төслийн хамт олонтой хамтран ажиллах болно.

Та бүхэн тусалж дэмжээрэй.



Нийслэлийн 29 дүгээр тусгай сургууль дээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслийн тухай (2018.04.06)

Нийслэлийн 29 дүгээр тусгай сургуулийн багш сурагчид өнгөрсөн сард манай төслийн оффист хүрэлцэн ирсэн билээ. Тус сургуулийн багш, сурагчдад тулгарч байгаа асуудал бол завсарлагааны хонх юм. Хонхны дууг сурагчид сондоггүйгээс болоод хичээл эхлэх, завсарлах, тарах цагаа тухай бүрд нь мэдэхгүй өнгөрөх явдал олонтой тохиолддог талаар ярьлаа. Төслийн багийнхан энэ талын асуудлыг Японд хэрхэн шийдвэрлэдэг талаар асууж, зөвлөгөө авахаар ирсэн юм.

Сонсголгүй иргэдийн сургуульд дуут хонхноос гадна гэрлэн дохиот хонхыг хэрэглэх нь энгийн үзэгдэл юм. Гэрлэн дохио нь өнгө өнгөөр ялгардаг бөгөөд тухайн өнгө нь юуны дохио болох нь сурагчдад ойлгомжтой байдаг талаар багийнханд ярьж өглөө. Гэрлэн дохиот хонхыг манайд хүрэлцэн ирсэн багш, сурагчдын аль аль нь мэдэж байсан ч бодит байдал дээрээ хэрхэн хэрэглэх талаар сайн мэдэхгүй эргэлзэж байгаагаа хэлэв.

29 дүгээр сургуульд урьд нь гэрлэн дохиот хонх хийх ажлыг зохион байгуулж байсан байна. Одоогоор нэг газар ийм гэрлэн дохиот хонхыг байрлуулсан байгаа нь багш сурагчдад ихээхэн тус нэмэртэй байгаа. Тэрийгээ улам боловсронгуй болгомоор байна гэцгээж байв. Сургуулийн хонхыг сайжруулах төслийн танилцуулга дээр зөвлөгөө авах хүсэлтийн дагуу өчигдөр манай төслийн зүгээс 29 дүгээр сургууль дээр очиж танилцлаа. Тус сургуулийн багш, сурагчдын баг нийт багш нарт төслийн талаар танилцуулав. Өнгө өнгөөр ялган хийж, багшынхаа зааврын дагуу 5 сурагч тус тусдаа хуваагдан танилцуулгыг хийж байлаа.

Сурагчид 3 багт хуваагдан, олон улсад ямар гэрлэн дохиот хонхыг хэрэглэж байгаа, гэрлэн дохиот хонхоор дамжуулан ямар мэдээллийг хүргэх боломжтой, энэ талын ямар хууль тогтоомжууд байдаг талаар мэдээлэл цуглуулсан байв. Сурагчид төр засгийн бодлогод нөлөөлж, нийгмийн орчныг бүрдүүлэхэд гар бие оролцсоноор өөрсдийн өмнө тулгарч байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар суралцах нь тус төслийн гол зорилго юм хэмээн багийг хариуцан ажиллаж байгаа Туул багш ярьлаа.

Хэрвээ энэ удаагийн сайн төсөл шалгаруулах уралдаанд шалгарах юм бол тодорхой хэмжээний төсөв мөнгөний асуудлаас шийдвэрлүүлэх юм байна. Бүгдэд нь амжилт хүсье.

Та бүхний хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь нийгмийг бүхэлд сайжруулахад хувь нэмэр болох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаас гадна сургуулийн орчныг сайжруулах чухал ач холбогдолтой гэдгийг сайтар ойлгож хичээцгээгээрэй.



Илтгэл тавих сурагчид



Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com